



*Үндэсний Аудитын Газрын Харьяа  
Дундговь Аймгийн Аудитын Газар*

# Үйл ажиллагааны тайлан 2015

[Дундговь аймаг]  
[Мандалговь хот 7-р баг]  
[Утас: 70592439, 70593208]  
Цахим хуудас [www.audit.mn](http://www.audit.mn)

**АГУУЛГА**

|                                                         |           |
|---------------------------------------------------------|-----------|
| <b>ТОВЧИЛСОН ҮГС.....</b>                               | <b>3</b>  |
| <b>Нэг. Ерөнхий зүйл.....</b>                           | <b>4</b>  |
| <b>Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар .....</b> | <b>5</b>  |
| <b>Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар.....</b>          | <b>7</b>  |
| <b>Дөрөв. Нийцлийн аудитын талаар .....</b>             | <b>9</b>  |
| <b>Тав. Эрсдэлийн аудитын талаар.....</b>               | <b>11</b> |
| <b>Зургаа. Дотоод ажлын талаар.....</b>                 | <b>11</b> |
| <b>Долоо. Хүний нөөцийн талаар.....</b>                 | <b>12</b> |
| <b>Найм. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд .....</b>        | <b>13</b> |
| <b>Ес. Олон нийтийн ажлын талаар.....</b>               | <b>15</b> |
| <b>Арав. Санал дүгнэлт.....</b>                         | <b>16</b> |

**ТОВЧИЛСОН ҮГС**

|               |                                                 |
|---------------|-------------------------------------------------|
| <b>УИХ</b>    | Улсын Их Хурал                                  |
| <b>ИТХ</b>    | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                    |
| <b>ҮАГ</b>    | Үндэсний Аудитын газар                          |
| <b>ССАЖЯ</b>  | Соёл Спорт Аялал Жуулчлалын Яам                 |
| <b>ЗДТГ</b>   | Засаг Даргын Тамгын Газар                       |
| <b>ММНБИ</b>  | Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт   |
| <b>АДБОУС</b> | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт   |
| <b>АОУС</b>   | Аудитын олон улсын стандарт                     |
| <b>ОНӨҮГ</b>  | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар             |
| <b>СТАУС</b>  | Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем |
| <b>ОНХС</b>   | Орон Нутгийн Хөгжлийн Сан                       |
|               |                                                 |
|               |                                                 |
|               |                                                 |
|               |                                                 |
|               |                                                 |
|               |                                                 |
|               |                                                 |
|               |                                                 |

## Нэг. Ерөнхий зүйл

Энэ онд Монгол улсад төрийн хөндлөнгийн хяналтын байгууллага үүсэн хөгжсөний 20 жилийн ойн баяр тохиосон, хамт олны бүрэлдэхүүн, удирдлага өөрчлөгдсөн онцлог жил байлаа.

Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвөлгөөнөөс 2015 онд “Хүний нөөцийн хөгжил, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх”, аймгийн Аудитын газраас “Боловсон хүчнийг хөгжүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, мэдээлэл технологийн ашиглалтыг сайжруулах” зорилтыг тус тус дэвшүүлж үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллалаа.

Тайлант онд үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн 7, нийцлийн 7, эрсдлийн 1, санхүүгийн тайлангийн 165 аудитыг тус тус хийж гүйцэтгэлээ. Аудитаар нийт 49,591.3 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж энэ нь өмнөх оноос 20,009.7 сая төгрөгөөр буюу 0.7 дахин өссөн байна.

Аудитаар нийт 49,591.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 66.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 47,477.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлж, 1021.1 сая төгрөгийн зөрчлийг аудит хийх явцад байгууллагуудын санхүүгийн тайланд залруулга хийлгэн, 1026.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.


Тайлант онд аудитаар өгсөн албан шаардлагын 41,940.4 сая төгрөг буюу 88.3 хувь нь хэрэгжиж, тогтоосон төлбөрийн актаас хуулийн байгууллагын шийдвэрээр 11.3 сая, Тэргүүлэх аудиторын тушаалаар 11.3 сая нийт 22.6 сая төгрөгийн актыг хүчингүй болгож, 35.3 сая төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэн актын барагдуулалт 80.6 хувь байна.

Аймгийн Аудитын газар 2015 онд нийт 47,804.0 сая төгрөгийн үр өгөөж бүртгэснээс 42,394.9 сая төгрөгийн үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлэн 1 төгрөгт ногдох үр өгөөжийг 206.0 төгрөгт хүргэлээ.

Бүртгэсэн үр өгөөж өнгөрсөн оноос 28,356.3 сая төгрөгөөр буюу 1.5 дахин, харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн 1 төгрөгт ногдох үр өгөөж 85.1 төгрөгөөр буюу 0.7 дахин өссөн байна.

Үйл ажиллагааны статистик үзүүлэлтийг өнгөрсөн онтой харьцуулбал:

| № | Аудитын төрөл         | Илрүүлэлт |          |          |       | Акт     |      |         |      | Албан шаардлага |          |          |         | Үр өгөөж |          |          |         |
|---|-----------------------|-----------|----------|----------|-------|---------|------|---------|------|-----------------|----------|----------|---------|----------|----------|----------|---------|
|   |                       | 2014 он   |          | 2015 он  |       | 2014 он |      | 2015 он |      | 2014 он         |          | 2015 он  |         | 2014 он  |          | 2015 он  |         |
|   |                       |           |          |          |       |         |      |         |      |                 |          |          |         |          |          |          |         |
|   |                       | тоо       | хувь     | тоо      | хувь  | тоо     | хувь | тоо     | хувь | тоо             | хувь     | тоо      | хувь    | тоо      | хувь     | тоо      | хувь    |
| 1 | Санхүүгийн тайлангийн | 22,018.6  | 19,729.3 | -2289.3  | 89.6  | 21.2    | 20.3 | (0.9)   | 95.8 | 1,198.3         | 18,833.3 | 17635    | 1,571.7 | 14,383.4 | 18,933.4 | 4550     | 131.6   |
| 2 | Гүйцэтгэлийн аудит    | 2,712.0   | 7,776.9  | 5064.9   | 286.8 |         | 2.6  | 2.6     |      | 2,498.3         | 7,582.6  | 5084.3   | 303.5   | 2,498.3  | 7,776.3  | 5278     | 311.3   |
| 3 | Бусад аудит           | 4,851.0   | 22,085.1 | 17234.1  | 455.3 | 81.3    | 43.5 | (37.8)  | 53.5 | 1,988.8         | 21,061.9 | 19073.1  | 1,059.0 | 2,566.0  | 21,094.3 | 18528.3  | 822.1   |
|   | дүн                   | 29,581.6  | 49,591.3 | 20,009.7 |       | 102.5   | 66.4 | (36.1)  |      | 5,685.4         | 47,477.8 | 41,792.4 |         | 19,447.7 | 47,804.0 | 28,356.3 | 1,265.0 |



Аудитад Сангийн яамнаас баталж гаргасан журмууд, Монгол улсын Ерөнхий аудиторын 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 203 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, болон Төрийн хяналт шалгалтын стандарт, АДБОУС, АОУС, “Гүйцэтгэлийн аудитын гарын авлага” холбогдох хууль, журам, аргачлалыг шалгуур болгон ашиглав.

Тайлант хугацаанд Санхүүгийн тайлангийн аудитын шинэ журмыг хэрэгжүүлэх, аудитад СТАУС программыг ашиглах ажлуудыг үр дүнтэй эхлүүллээ.

### Хоёр. Санхүүгийн тайлангийн аудитын талаар

Төсвийн тухай хуулийн 8.9.1, 8.9.2, 8.9.3, 8.9.4, 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 18.2, 18.3 дах заалтын дагуу 2015 онд улс, орон нутгийн төсвийн байгууллага, тусгай зориулалтын сангууд, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын /ОНӨҮГ/ 2014 оны жилийн эцсийн санхүүгийн болон нэгтгэсэн тайланд аудит хийлээ. Үүнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төвлөрүүлэн захирагчийн 16, төсөл сангийн 16, улсын төсвийн байгууллагын 30, тусгай шилжүүлгийн байгууллагуудын 75, орон нутгийн төсвийн байгууллагын 41, ОНӨҮГ-ын 18, нийт 197 байгууллагад аудит хийхээс 28 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулан, 72 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитыг “Саруул баян уул аудит” ХХК, “Дундговь аудит” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. Гэрээгээр гүйцэтгүүлсэн аудит нийт аудитын 36 хувийг эзэлж байна.


Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 169 дүгнэлт гарахаас 165 дүгнэлт өгч, 4 дүгнэлт дутуу гарсан байна. Энэ нь гүйлгээ хийгдээгүйгээс Хүний хөгжил сан, аудитад тайлан материалаа ирүүлээгүйгээс 2 сумын эм эргэлтийн сан, Авто тээврийн үндэсний төвийн Дундговь дах салбар санхүүгийн тайлан гаргадаггүй гэсэн шалтгаанаар тус тус аудитад хамрагдаагүйтэй холбоотой болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар Сумдын Засаг даргын нөөц сан болон багуудын санхүүгийн тайлангийн хаалтын балансыг гаргуулж, ЗДТГ-ын санхүүгийн тайланд нэгтгүүлэн аудитыг гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд тайлант хугацаанд дунджаар **474** хүн өдөр зарцуулахаас **496** хүн өдөр зарцуулж, 1 аудитор дунджаар **24** байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргалаа.

Аудит хийлгэсэн байгууллагын “Санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайланг нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэхэд дүгнэлт өгч баталгаажуулах”-ын тулд санхүүгийн тайлан нь материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж, үндэслэлтэй нотолгоонд тулгуурлан дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **165** санал дүгнэлт гарсны 91.5 хувь буюу **151** нь “Зөрчилгүй”, 6.7 хувь буюу **11** нь “Хязгаарлалттай”, 0.6 хувь буюу **1** нь “Сөрөг”, 1.2 хувь буюу **2** нь “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт байна.



Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг УАГ-ын Санхүүгийн аудитын газарт болон холбогдох төсвийн ерөнхийлөн, төвлөрүүлэн, шууд захирагч нарт хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Аудитаар нийт **19,729.3** сая төгрөгийн зөрчил илэрснээс **20.3** сая төгрөгийн **54** төлбөрийн акт тогтоож, **18,687.9** сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай **155** албан шаардлага хүргүүлж, **34.2** хувь буюу **1,021.1** сая төгрөгийн зөрчлийг аудит хийх явцад байгууллагуудын санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитаар илэрсэн нийт зөрчлийн **63.1** хувь нь бүртгэл тайлагнал, хууль журмын холбогдох заалтыг зөрчсөн тушаал шийдвэр гаргаснаас үүссэн зөрчил байгаа нь төсвийн байгууллагын менежер, нягтлан бодогч нарын хууль эрх зүйн мэдлэг дутмаг, санхүүгийн үйл ажиллагаанд, тавих дотоод хяналт хангалтгүйг харуулж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт **18,933.4** сая төгрөгийн **212** үр өгөөж бүртгэснээс тайлант хугацаанд **18,945.8** сая төгрөгийн 198 үр өгөөжийг харилцагч байгууллагаар хүлээн зөвшөөрүүлсний **202.3** сая төгрөгийн 5 үр өгөөж нь өмнөх оны үлдэгдлээс тооцогдсон байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Хязгаарлалтай буюу Сөрөг санал дүгнэлт авсан, санхүүгийн дотоод хяналтыг бүрдүүлж ажиллаагүй, ажилдаа хариуцлагагүй хандаж аудитын хугацаа хоцроосон, зэрэг зөрчил гаргасан **18** төсвийн шууд захирагч, санхүүгийн ажилтанд хариуцлага тооцох албан шаардлагыг томилсон эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж хэрэгжилтийг нь тооцож ажиллав.

СТАУС программыг нэвтрүүлэх, 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын бэлтгэл ажлын хүрээнд аймгийн төвийн 44 байгууллагын холбогдох 69 албан тушаалтанд тэргүүлэх аудитор, аудитын менежер мэдээлэл өглөө. Энэ арга хэмжээнд, санхүүгийн аудитын багийн аудитор шинжээчид, Санхүүгийн тайлангийн аудитын ажлыг гэрээгээр гүйцэтгэх Саруул баян уул аудит ХХК, Panthere midland аудит ХХК-уудын захирал аудиторууд оролцож аудит хийх талаар чиглэл өгч аудитын захидлыг хүргүүллээ.



Аймгийн хэмжээнд улс, орон нутгийн төсвийн нийт 145-н төсвийн шууд захирагч, 1 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 3-н тусгай сан, 16-н төсвийн төвлөрүүлэн захирагч, 1 төсвийн ерөнхийлөн захирагч нийт 166 байгууллага, сангийн үндсэн мэдээлэл, судалгааг холбогдох байгууллагуудаар баталгаажуулан СТАУС програмд орууллаа. СТАУС програмыг цаашид сайжруулах саналыг бэлтгэж ҮАГ болон програм хангамжийг боловсруулсан “Смарт грийн технологи” ХХК-ийн мэргэжилтнүүдэд өгсөн.

### Гурав. Гүйцэтгэлийн аудитын талаар

Тайлант онд УИХ-ын төсвийн байнгын хорооны захиалга, ҮАГ-ын төлөвлөгөө нэгдсэн удирдамжаар 5, аудитын газрын төлөвлөгөө хөтөлбөрөөр 5, нийт 7 гүйцэтгэлийн аудит хийхээр төлөвлөснийг бүрэн хийлээ.

Аудит бүрийн дүнг шалгагдагч байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтан бусад холбогдох албан тушаалтанд танилцуулан Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж аудитын тайланг Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулав.

Гүйцэтгэлийн аудитаар нийт **7,776.9** сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж **7,582.6** сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага **54**-ыг хүргүүлж, **2.6** сая төгрөгийн зөрчилд **3** төлбөрийн акт тогтоож, **191.7** сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө. Дээрх зөрчлөөс **7030.1** сая төгрөгийн **52** албан шаардлагыг



хэрэгжүүлж биелэлт 92.7 хувь, 1.9 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг барагдуулж биелэлт 73 хувь байна.

Монгол улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийх гүйцэтгэлийн аудиттай холбоотой судалгааг нэгтгэж ҮАГ-т хүргүүлсэн. Судалгаагаар манай аймагт хамаарах үзүүлэлтийн хувьд эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт 78.8 хувьтай гарсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн боловч орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээ орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцээгүй байна.” гэсэн дүгнэлт өгөв. Аудитаар нийт 6,884.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 6,883.9 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг барагдуулахаар 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо. Аудитын тайланг хугацаанд нь ҮАГ, аймгийн Засаг дарга, ИТХ-д тус тус хүргүүлэв.

Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийх гүйцэтгэлийн аудит хийж “Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй Төсвийн тухай хуулийн 34.2-т заасан нөхцөл шаардлага үүсээгүй байхад тодотгол хийсэн байна.” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн. Аудитаар нийт 80.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллав. Аудитын тайланг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газарт хугацаанд нь хүргүүллээ.

ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Ажилтай монгол хүн, Эрүүл монгол хүн” хөтөлбөрт Дундговь аймагт тодорхойлсон Ажилтай монгол хүн хөтөлбөрийн 19, Эрүүл монгол хүн хөтөлбөрийн 26 арга хэмжээний хэрэгжилтийн талаарх тайлан мэдээллийг аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Эрүүл мэндийн газраас гаргуулан судалгааг нэгтгэж ҮАГ-т хугацаанд нь хүргүүлсэн.

ОНӨҮГ-үүдйн үйл ажиллагаа, үр дүнд Аудитын газар өөрийн төлөвлөгөөгөөр гүйцэтгэлийн аудит хийлээ. Аудитаар нийт 701.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс, 580.0 сая төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлж, 1.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож 119.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөөд байна. Аудитаар “Зах зээлийн харьцуулсан судалгаа хийгээгүй хууль эрх зүйд нийцсэн эсэхийг харгалзалгүй, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж, үр ашгийг урьдчилан тооцолгүйгээр Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулсан байна” гэсэн дүгнэлт өгсөн. Аудитаар аймгийн Засаг даргад 3, Эрүүл мэндийн газарт 2, Засаг даргын Тамгын газарт 2, Орон нутгийн өмчийн албанд 2, Дундговь ус ОНӨҮГ-т 3, Нийтлэг үйлчилгээний албанд 2 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт-д гүйцэтгэлийн аудит хийж тайланг 2015 оны 11 сарын 05 –ны өдөр ҮАГ-т болон аймгийн Засаг даргад хүргүүллээ. Дундговь аймгийн нутагт нийт 193 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаагаас 73 ашиглалт, 120 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байна. “Орон нутагт Байгаль орчныг хамгаалахтай холбоотой хууль журам бүрэн хэрэгжээгүй, нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгийг дутуу төвлөрүүлж, зориулалт бусаар хяналтгүй зарцуулж, нөхөн сэргээлтийн ажил хангалтгүй хийгдсэн байна” гэсэн ерөнхий дүгнэлт өгсөн. Аудитын явцад нийт 110.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 38.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар



хугацаатай албан шаардлага хүргүүлж, 72.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллаа. Байгаль орчны аялал жуулчлалын яаманд 2, Ашигт малтмалын газарт 2, Аймаг, сумдын засаг дарга нарт 6 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүлэв.

**Орон нутгийн 2016 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх санал** боловсруулахтай холбогдуулан судалгаа хийж, төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх саналыг аймгийн ИТХ-д оруулж хэлэлцүүлээ. Аймгийн ИТХ-д оруулсан санал дэмжигдэж 50.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг нэмж батлуулав.

### Дөрөв. Нийцлийн аудитын талаар

Тайлант хугацаанд ҮАГ-ын нэгдсэн удирдамж, Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу 4, байгууллагын өөрийн санаачлагаар 2 нийцлийн аудит хийхээр төлөвлөж аудитыг бүрэн хийсэн. Мөн төлөвлөгөөт аудитаас гадна ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөрөөр “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д нийцлийн аудитыг хийж тайланг баталгаажуулан Нийцлийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлээд байна.

Аудитаар нийт **9,302.4** сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 976.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгч, **18.6** сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, **8,307.4** сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлээд байна.

1. **Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад** нийцлийн аудит хийж “Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөөгүй, иргэдийн оролцоог хангаагүй, хэт жижиг урсгал шинжтэй зардалд, хяналт муутай зарцуулнаас зарим хөрөнгө оруулалт хийгдээгүй, хөрөнгийн ашиглалт хангалтгүй байгаад анхаарч сангийн хөрөнгийг үр ашигтай өгөөжөө өгөх томоохон арга хэмжээнд зарцуулах шаардлагатай байна” гэсэн дүгнэлтийг өглөө. Аудитаар нийт **9,267.6** сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар **8,284.4** сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, **983.2** сая төгрөгийн алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах талаар аудитын явцад зөвлөж ажиллалаа. Аудитын тайланг ҮАГ, аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Төрийн аудитын байгууллагаас тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 15 дугаар тогтоол, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй гэсэн үндэслэлээр Аймгийн Засаг даргыг үүрэгт ажлаас огцруулах саналыг холбогдох байгууллагуудад уламжиллаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) хөрөнгөөр хийгдэж буй зарим төсөл арга хэмжээнүүд иргэдийн санал аваагүй, санал асуулгаар дэмжигдээгүй, хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинжтэй олон жижиг ажил хийгдэж байгаа нь үр нөлөө багатай байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 1.2-т "ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангасны үндсэн дээр иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин бүрдүүлэхэд чиглэгдэнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Сумдад худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн дадлага туршлагатай гишүүд дутмаг байдгаас шаардлага хангахгүй оролцогчтой шууд гэрээ байгуулах, тендерийг хүчингүй болгож, тендерт шалгараагүй иргэн аж ахуй нэгжтэй гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хянаж дүгнэдэггүй, ажил гүйцэтгэх гэрээнд хүлээх

хариуцлагыг тодорхой тусгаж өгөөгүйгээс гэрээний хугацаанд ажлаа хийж дуусгаагүй зөрчлүүд гарч байна.

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнг харьцуулсан судалгаа хийхэд залруулагдаагүй алдаа 2015 онд 2014 оноос 7.6 сая төгрөгөөр өссөн байна.

2. МУ-ын ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцаас хэрэгжүүлсэн аймгуудын нэгдсэн оношлогооны төв байгуулах төслийн хэрэгжилт” сэдэвт аудитын хувьд манай аймаг тухайн төсөлд хамрагдаагүй тул аудит хийгдээгүй болно.
3. Газрын тухай хуулийн хэрэгжилт-д Аудитын газар өөрийн санаачлагаар нийцлийн аудит хийлээ. Аудитаар нийт 32.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 14.1 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, хохирлыг барагдуулахаар 18.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогоод байна. Аудитаас “Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй, газрыг дуудлага худалдаа сонгон шалгаруулалтгүйгээр олгож, газрын төлбөрийг үзүүлэлт бүрээр бүрэн ногдуулаагүй байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өгч аймгийн ИТХ-д 3, аймгийн ЗДТГ-т 3, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт 5 заалт бүхий зөвлөмжийг тус тус хүргүүллээ.
4. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд нийцлийн аудит хийж аудитын тайланг УАГ-т болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүллээ. Дундговь аймагт Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитад Замын сан, Соёл урлаг хөгжүүлэх сан, Дархлаажуулалтын сан нийт 3 сан хамрагдав. Замын санд хийсэн аудитаар “Зам засварын ажлын дутууг нэмэлт гэрээ хийлгүйгээр гүйцэтгүүлж, комисс ажлыг хүлээж аваагүй байна” гэсэн ерөнхий дүгнэлтийг өглөө. Аудитын явцад нийт 4.2 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж уг зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгөв. Аудитаар Хот тохижуулах албанд-2, Хөгжлийн бодлогын хэлтэст-1 зөвлөмж тус тус хүргүүлэв. “Дархлаажуулалтын сангийн хөрөнгийг журмын дагуу зарцуулсан боловч, зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.” гэж дүгнэсэн. Эрүүл мэндийн газарт 4 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв. Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа соёл, урлаг хөгжүүлэх сан байхгүй, харин ССАЖЯ-ны харьяа Соёл, урлаг хөгжүүлэх сангаас байгууллагын нэмэлт санхүүжилтын дансаар дамжуулан музейн үзмэр худалдан авахад санхүүжилт олгосон байна. Аудитаар “Сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан зориулалтын дагуу зарцуулсан боловч бүртгэлийн алдаа гаргасан” гэж дүгнэн бүртгэл буруу хийснээс гарсан алдааг аудитын явцад залруулах зөвлөмж өгсөн.
5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт-д Төлөвлөгөөт аудитаас гадна УАГ-ын нэгдсэн удирдамж, төлөвлөгөө хөтөлбөрөөр 2015 оны 10 дугаар сарын 20-ноос 2015 оны 12 дугаар сарын 15-н хүртэлх хугацаанд нийцлийн аудитыг гүйцэтгэсэн. Аудитад нийт 149 байгууллага хамрагдаж, аймгийн төвийн байгууллагууд, хөдөөгийн 5 сумын байгууллагыг газар дээр нь шалгаж, зарим сумдыг /10/ түүвэрлэн судалгаанд хамрууллаа. Аудитаар нийт 39.5 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж хугацаатай албан шаардлага өгөв. Аудитын судалгаа, тайланг 2015 оны 12 дугаар сарын 15-нд УАГ-т хүргүүлсэн.
6. Аудитын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан **Халамжийн сангийн төлөвлөлт, зарцуулалтад** нийцлийн аудит хийж байна. Төлөвлөсөн хугацаанд

“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д аудит хийх болсон, хүний нөөц дутуу ажилласан зэргээс шалтгаалан аудитын хугацааг хойшлуулан одоо гүйцэтгэлийн үе шатны ажил хийгдэж байна.

7. **Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгох бодлогын хэрэгжилтэд** Дундговь аймагт хэрэгжсэн арга хэмжээ байхгүй тул аудит хийгдээгүй.

### Тав. Эрсдэлийн аудитын талаар

Тайланд онд аудитын газрын өөрийн төлөвлөгөөгөөр Боловсрол соёлын байгууллагын 2014, 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд эрсдлийн аудитыг хийсэн. Аудитад нийт 39 байгууллагыг хамруулж **12,782.7** сая төгрөгийн зөрчил илрүүлэн, **25.3** сая төгрөгийн зөрчилд 26 төлбөрийн акт тогтоож, **12,757.4** сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 88 хугацаатай албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүллээ. Аудитаар Боловсрол соёлын байгууллагууд “НББ-ийг стандартын дагуу хөтлөөгүй, хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд тавих дотоод хяналт суларсан, шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна” гэж дүгнэсэн.

Аудитаас аймгийн ИТХ-д 1, Санхүү төрийн сангийн хэлтэст 2, Орон нутгийн өмчийн албанд 1, Боловсрол соёлын газарт 11 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн.

### Зургаа. Дотоод ажлын талаар

Монгол Улсын Ерөнхий аудиторын шинэчлэн боловсруулж баталсан ажлын байрны тодорхойлолтыг бүх ажилтнууд мөрдөн ажиллаж байна.

Аймгийн Тэргүүлэх аудитор Монгол Улсын Ерөнхий аудитортой, бусад ажилтнууд Тэргүүлэх аудитортой үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Ахмад настнаа дээдлэх зорилгоор цагаан сар, ахмадын өдөр, Төрийн хяналтын байгууллагын 20 жилийн ой зэрэг тэмдэглэлт өдрүүдээр байгууллагын болон харьяа ахмадуудаа хүлээн авч хүндэтгэл үзүүлэв.

Ажилтнуудын үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас, бүтэн жилээр дүгнэж, ажилтнуудад үр дүнгийн урамшууллыг олголоо.

Төрийн аудитын байгууллага байгуулагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан ажилтнуудын ажлын амжилтыг үнэлж Тэргүүлэх аудитор Б.Долгорсүрэнг Хөдөлмөрийн хүндэт медаль, аудитын менежер Б.Гантуяаг Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдэг, ММНБИ-ийн хүндэт тэмдэгээр, ахлах аудитор Т.Батсайханг Төрийн хяналтын тэргүүний ажилтан цол тэмдгээр тус тус шагнагдлаа.

#### Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар

Өнгөрсөн оны дотоод ажлын болон аудитын ажлын баримт материалыг зохих стандарт заавар журмын дагуу эмхлэн цэгцэлж 23 боть болгон үдэж байгууллагын архивт шилжүүлсэн.

Архивын улсын үзлэгт бэлтгэх, байгууллагын архивт хадгалагдаж байгаа 2003 оноос хойших хадгаламжийн нэгжүүдийг ангилан ялгаж, аймгийн архивт шилжүүлэх байнга хадгалагдах материалыг стандартын дагуу цэгцэлж, хадгалах хугацаа дууссан устгах материалын жагсаалтыг хянуулахаар аймгийн баримт бичиг нягтлан шалгах комисст хүргүүлэхээр бэлтгээд байна.

Улсын архивын үзлэг шалгалтын хүрээнд бэлтгэл ажлыг хангах төлөвлөгөө боловсруулан ажиллаж аймгийн архивын үзлэгт хамрагдан 85.6 оноо буюу “В” үнэлгээтэй дүгнэгдлээ.

Тайлант онд 661 албан бичгийг хүлээн авч бүртгэн, хариуг хугацаанд нь хүргүүлж, 279 албан бичгийг холбогдох байгууллагад явууллаа.

Байгууллагын хэрэгцээнд хэрэглэгдэх албан хэргийн болон аудиторын тайлан, акт, албан шаардлагын хэвлэмэл хуудсыг заавар, журам, стандартын дагуу дугаарлан бэлтгэж ажилласан.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтын дагуу ажилтнуудын 2014 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулж, нэгтгэн ҮАГ-т хүргүүллээ.

Авилгатай тэмцэх газраас Дундговь аймагт 2015 оны 11 дүгээр сард зохион байгуулсан 1 өдрийн сургалтанд бүх ажилтнууд хамрагдав.

Аудитор, шинжээчийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн Х.Гарам, Ж.Угтахбаяр, Г.Пагмарулам, Т.Энхнаран нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулж, ҮАГ-т хүргүүлж хянуулан, ХАС, ХОМ-ыг гаргуулан цахим санд бүртгэж баталгаажууллаа

#### Төсөв санхүү, мэдээллийн ил тод байдал

Аудитын газар 2015 онд 188.4 сая төгрөгийн төсөв батлагдан, төсвийн шууд захирагчаас 17.3 сая төгрөг хуваарилагдаж, нийт 204.1 сая төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 195.3 сая төгрөгийг холбогдох зардалд зориулалтын дагуу зарцуулав.

Байгууллагын 2014 оны санхүүгийн тайланд “Дундговь аудит” ХХК-иар аудит хийлгэн “Зөрчилгүй” дүгнэлт авсан. Байгууллагын хөрөнгийн дансанд бүртгэлтэй эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилээр хийж тооцоог бодож баталгаажуулан санхүүгийн зөрчилгүй ажиллалаа.

Төсвийн зарцуулалтын тайлан мэдээг сар бүр гаргаж ҮАГ-т хүргүүлж ажилласан. Байгууллагын үйл ажиллагааг ил тод болгох зорилгоор Дундговийн амьдрал сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулан аудитын дүнгийн талаар мэдээллийг тогтмол хүргүүлж, аудитын дүнг олон нийтэд хүртээхээр ҮАГ-ын нэгдсэн вэб сайт [dundgovi.gov.mn](http://dundgovi.gov.mn) сайт, facebook хуудсанд, гүйцэтгэл, нийцлийн аудитын тайлангуудыг байршуулж ажиллаа.

Байгууллагын мэдээллийн самбараар үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол хүргэж байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад сар бүр цаг хугацаанд нь тогтмол оруулж ажиллалаа.

## Долоо. Хүний нөөцийн талаар



Монгол улсын Ерөнхий аудиторын 2015 оны 08 сарын 21-ны өдрийн 199 тоот тушаалаар Аудитын газрын Тэргүүлэх аудитораар Нийслэлийн аудитын газарт аудитораар ажиллаж байсан Т.Оюунчимэгийг томилон ажиллууллаа.

Боловсон хүчний хувьд 2015 онд нэмэж батлагдсан нэг орон тоонд сонгон шалгаруулалт явуулж Улсын бүртгэлийн хэлтэст нягтлан бодогчоор ажиллаж байсан мэргэшсэн нягтлан бодогч Х.Гарамыг аудитораар томилуулан санхүүгийн аудитын багт ажиллуулж байна. Тайлант онд гарсан сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулж аймгийн Холбооны газарт нягтлан бодогчоор ажиллаж байсан Ж.Угтахбаярыг туршилтын хугацаагаар шинжээчээр, хүүхэд асрах чөлөөтэй байгаа аудиторуудын түр ажлын байранд Г.Пагмарулам, Т.Энхнаран нарыг шинжээчээр томилуулан ажиллаж байна.

Шинжээч Д.Должинсүрэн, аудитор Х.Гарам нарын туршилтын хугацаа дууссан тул Төрийн аудитын байгууллагын ажилтны тангараг өргүүллээ.



Ажилтнуудын ажилласан жил, мэргэшлийн зэрэг, дэв, төрийн албан хаагчийн тангараг өргөсөн материалуудыг холбогдох журмын дагуу тухай бүр бүрдүүлэн төрийн албан хаагчдын хувийн хэрэгт баяжуулалт хийж ажилласан.

Байгууллагын бүх ажиллагсдын хурлыг 2015 оны 12-р сарын 30-нд хийж, ажилтнуудын үр дүнгийн гэрээний дүн, өнгөрсөн тайлант онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, амжилт ололт, алдаа дутагдлаа хэлэлцэж, удирдлагын зүгээс ажилтнуудад анхаарах асуудлыг сануулж, ирэх онд байгууллагад хэвшүүлэх ажил, дэвшүүлэх зорилтоо тодорхойлов.

### Найм. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд

Даваа гариг бүрийг сургалтын өдөр болгон Тасралтгүй боловсролын хөтөлбөрт тусгагдсан 14 сэдвийн хүрээнд 8 удаагийн 14 кредит цагийн хичээлийг өөрсдийн нөөц бололцоог ашиглан явуулж ажиллагсад 100 хувь оролцсон байна.

Дэлхийн энх тайвны корпусын сайн дурын багш нараар англи хэлний сургалтыг эхний хагас жилд зохион байгуулж бүх ажилтнуудыг хамрууллаа.

ММНБИ-с зохион байгуулсан нээлттэй хаалганы өдөрлөгт тэргүүлэх аудитор Т.Оюунчимэг “Төрийн аудитын хөгжил, шинэчлэлт” сэдвээр илтгэл тавьж, аудитор Х.Гарам, шинжээч Д.Должинсүрэн Т.Энхнаран, Пагмарулам нар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Эдийн засгийн ил тод байдлын тухай хуулийн талаар сургалт хэлэлцүүлэгт хамрагдав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт” болон “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэгт шинжээч нягтлан бодогч Д. Должинсүрэн оролцов.

2015 оны 11 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Стратеги удирдлагын газар санхүүгийн аудитын газраас АДБОУС, СТАУС програмын талаарх ажлын байрны сургалтыг зохион байгуулж аудитын газрын нийт ажилтнууд хамрагдлаа.



Тайлант хугацаанд:

- Тэргүүлэх аудитор Б.Долгорсүрэн Төрийн аудитын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд,
- Аудитын менежер Б.Гантуяа Турк улсад “Гүйцэтгэлийн аудит” сэдэвт сургалтанд
- Ахлах аудитор Х.Наранцацрал Улаанбаатар хотод “Гүйцэтгэлийн аудит” сэдэвт сургалтанд тус тус хамрагдав.
- Ахлах аудитор Х.Наранцацрал, аудитор С.Чинбат нар ММНБИ-ээс зохион байгуулдаг мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах сургалтанд амжилттай суралцаж 5 жилийн эрх, ахлах аудитор Т.Батсайхан хугацаагүй эрх авлаа.
- Шинжээч Ч.Бэрхсайхан Олон улсын аудитын дээд байгууллагын хөгжлийн санаачлагаас зохион байгуулж буй Гамшгийн эрсдлийн удирдлага сэдэвт хамтарсан гүйцэтгэлийн аудит хөтөлбөрт хамрагдаж 1-р шатыг амжилттай дуусгасан.

- Шинжээч Д.Должинсүрэн Мэргэшсэн нягтлан бодогчийн институтээс зохион байгуулсан санхүүгийн бүртгэл болон зардлын бүртгэлийн 10 хоногийн сургалтанд өөрийн зардлаар суралцаж мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалт өгч хуулийн шалгалтанд тэнцсэн.
- Засгийн газраас Дундговь аймагт зохион байгуулсан Шилэн дансны сургалтанд шинжээч Д.Должинсүрэн хамрагдлаа.

### Ес. Олон нийтийн ажлын талаар

Дундговь аймгийн Аудитын газар Хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага байгуулагдсаны 20 жилийн ойг 2 үе шаттай тэмдэглэн өнгөрүүлээ.

Эхний үе шат буюу ойн нэгдсэн арга хэмжээ энэ оны 7 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд Булган аймгийн Рашаант сумын нутаг Хөгнө тарнийн байгалийн цогцолборт газарт зохион байгуулагдаж Дундговь аймгийн Аудитын газрын хамт олон энэ арга хэмжээнд амжилттай оролцож үндэсний хувцас, нутгийн ёс заншлыг харуулсан үзүүлбэрт 3 дугаар байрт шалгарч, шинжээч Ч.Бэрхсайхан сурын харвааны төрөлд дэд байрт шалгаран мөнгөн медаль хүртсэн.



Хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага байгуулагдсаны 20 жилийн ойн хоёр дах шатны арга хэмжээг орон нутагт 10 дугаар сарын 02-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлээ.

Энэ арга хэмжээний хүрээнд:

□ Аймгийн Аудитын газрын хамт олон төрийн хяналтын байгууллагад ажиллаж байсан үе үеийн ахмадуудтай “Дурсамж уулзалт” зохион байгуулсан. Уулзалтын үеэр Ардын хянан шалгах хорооны даргаар 17 жил ажилласан өндөр настан Б.Цэдэнбалжир, Хянан шалгах хорооны дарга, аймгийн Аудитын газрын Ерөнхий аудитораар ажиллаж байсан О.Чулуунбат нар үе үеийн түүхийг дурсан ярьж, залуучуудад хандан сургаал үгээ хэлэв.

□ Харилцагч төсвийн байгууллагуудын төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудын дунд гар бөмбөгийн тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Энэ тэмцээнд Татварын хэлтсийн баг тэргүүлж алтан медаль, Боловсрол-1 баг дэд байрт шалгарч мөнгөн



медаль, Онцгой байдлын хэлтэс, Тагнуул, Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын хамтарсан “Дөл” баг гутгаар байрт шалгарч хүрэл медаль хүртлээ.

□ Ойн арга хэмжээг тохиолдуулан харилцагч төсвийн байгууллагуудаас ажлын амжилтаараа шалгарсан санхүүгийн ажилтнуудад “Хүндэт өргөмжлөл” гардуулж урамшууллаа.

Аймгаас зохион байгуулсан олон нийтийн ажилд хамт олноороо идэвхитэй оролцож, орчны хог, цас цэвэрлэн, өвөлжилтийн бэлтгэл хангахад зориулан халтар хомоол түүж Сайнцагаан сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өглөө.

Аймгийн хэмжээнд “Бүртгэл санхүүгийн ажилтны баяр”-т зориулсан гар бөмбөгийн тэмцээнд багаараа амжилттай оролцож шилжин явах цомыг гардан авлаа.

### Арав. Санал дүгнэлт

Тайлант хугацаанд үйл ажиллагаандаа Төрийн аудитын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон, Аудитын Олон улсын стандартад нийцүүлэн, ёс зүйн хэм хэмжээг сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллалаа.

Манай байгууллагын хувьд сүүлийн хагас жилд хүний нөөц дутуу, цаг хугацаа шахуу, ажлын ачаалалтай ажиллаж, төлөвлөсөн ажлаа хугацаанд нь биелүүлсэн байна. Өнгөрсөн тайлант онд хийж гүйцэтгэсэн ажлын амжилт ололт, алдаа дутагдлаа дүгнэн цэгнэж ирэх оны зорилтоо тодорхойлсон.

Байгууллагын ажилтнууд болон удирдлагын зүгээс дараах саналуудыг дэвшүүлэв. Үүнд:

Ажилтнуудаас:

- Төлөвлөгөөт аудитын үеэр аудитор шинжээч нарыг өөр ажилд томилон ажиллуулахгүй байх
- 12 дугаар 1-нээс хойш аудит хийхгүй байхаар төлөвлөх. Жилийн эцэст аудитор шинжээч нарыг акт албан шаардлагын хэрэгжилтийг хангах, мэдээ тайлан нэгтгэх, дараа оныхоо бэлтгэл ажлыг хангах цаг боломжоор хангаж өгөх
- Ажлын болон ажлын бус өдрөөр ажилласан илүү цагийг холбогдох хууль болон дотоод журмын дагуу нөхөн амруулж байх гэсэн саналуудыг гаргасан байна.

Удирдлагаас:

**I. Аудитын менежер, ахлах, аудитор шинжээч нарт:**

1. Аудитын тайлангийн чанар, хугацаанд анхаарах, тайланг багаар хэлэлцэж алдааг сайн нягталж шалгасны дараа хянуулж хэвших
2. Тайлангийн загварыг стандартын дагуу шинэчлэн сайжруулах
3. Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэх
4. Байгууллагын соёл, харьцааны соёлыг төлөвшүүлэх, харилцагчид болон багийн бусад гишүүдтэй хүндэтгэлтэй харьцах дадал бий болгох
5. Албан бичиг, тайлан бичихдээ найруулга, үг үсгийн алдаа гаргахгүй хянамгай ажиллаж, бичгийн соёлыг сайжруулах
6. Багаар хамтран ажиллахдаа хүн бүр адил тэгш үүрэг хүлээж, ажлын хариуцлагыг дээшлүүлэх

7. Аудитор шинжээч нар хийсэн ажлаа тухай бүр менежерээр хянуулж арга зүйн туслалцаа авч, зааварчилгааг хэрэгжүүлж ажиллах
8. Аудитын тайлан, мэдээ судалгааг цаг хугацаанд нь холбогдох газрууд болон олон нийтэд хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг тогтмолжуулах
9. Байгууллагын эрх ашиг, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн дээдлэж, ажилдаа сэтгэлтэй санаачилгатай ажиллах
10. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх шаардлагад нийцүүлэн, стандарт, гарын авлага, хууль журам, дүрмийг уншиж судлан, өөрийгөө хөгжүүлэх, мэргэшлээ дээшлүүлэхэд анхаарах

## **II. Байгууллагад 2016 онд хэвшүүлэх ажлууд:**

1. Байгууллагын 7 хоног бүрийн шуурхай цуглаанаар өгсөн үүрэг даалгавар түүний биелэлтэд үнэлэлт өгч, баримтжуулах
2. Гүйцэтгэсэн аудит бүрийн дараа "Аудиторын ажлын гүйцэтгэлийг үнэлэх хүснэгт" - ээр үнэлгээ өгөх
3. Тайланг стандартын дагуу бичиж цаг хугацаанд нь хянуулсан талаар үнэлэлт өгөх /загвар маягт боловсруулах/
4. Ажиллагсад чөлөөг албан ёсоор бичгээр авах /чөлөөний хуудсаар/
5. Удирдлагын зөвлөлийн хурлаар асуудлыг тогтмол хэлэлцэж байх
6. Аудит дууссан тухай бүр ажлын баримт материалыг үдэж, архивт хүлээлгэн өгөх
7. Цахим архив бүрдүүлэх
8. Төрийн аудитын түүхийг бүтээж буйн хувьд байгууллагын үйл ажиллагааны мэдээ судалгааг он оноор нэгтгэн архивлах, зурагт альбомд баяжилт хийх гэсэн саналуудыг ажилтнууд дэмжив.

## **III. Байгууллагын 2016 онд дэвшүүлэх зорилт:**

- ❖ Боловсон хүчнийг чадваржуулах, хариуцлагыг дээшлүүлэх
  - ❖ Харилцааны соёл, харилцан биенээ хүндэтгэх байгууллагын соёлыг төлөвшүүлэх,
  - ❖ Аудитын тайлангийн чанарыг сайжруулах
- гэсэн зорилт дэвшүүллээ.

Цаашид манай хамт олон төрийн аудитын шинэчлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн төлөө хичээж ажиллах болно.

ТӨРИЙН МЭЛМИЙ ХУРЦ, ТУНГАЛАГ,  
ТҮМЭН ОЛОН АМГАЛАН БАЙГ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР